



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/48

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хэсэгчлэн шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэн Боржигон овогт Маамхүүгийн Батдолгор (ЙБ72030208)-ын 6221002546 нэгж талбарын дугаартай, худалдаа үйлчилгээний зориулалт бүхий 298 м² газрын 56 м² газрыг иргэн Боржигон овогт Цээтаяагийн Ичинхорлоо (ГП88030101)-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар 32 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын "Газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх тухай" 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/89 дүгээр захирамжийн М.Батдолгор (ЙБ72030208)-т холбогдох заалт, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН